

## **ЗАХИРЛЫН МЭДЭЭЛЭЛ**

Сайн байцгаана уу,

10 сарын 8-ны Пүрэв гарагт ОУДС-ийн хамт олон бид Жилийн Ерөнхий Хуралдаанаа хийлээ. Энэ хуралд маш олон эцэг эхчүүд ирж оролцон сургуулийн тухай, өнгөрсөн жилд бидний хийсэн ажил болон сургуулийн санхүүгийн талаар мэдээлэл авч үр дүнтэй хурал болж өнгөрлөө.

Сургуулийн Удирдах Зөвлөлд олон эцэг эхчүүд нэр дэвшсэнээс Mr. Oddvar Aadnanes, Mrs. Munkhtsetseg Chultem (дахин сонгогдсон), Mrs. Khulan Dashdavaa, Mr. John Karlsen, Mr. Sejoon Oh, Mr. David Reiner (дахин сонгогдсон), Mrs. Nalin Sharma нар сонгогдлоо.

**ОУДС-д Олон Улсын Дунд Сургуулиудын Зөвлөлийн (Council of International Schools) төлөөлөгч хатагтай Margaret Alvarez энэ долоо хоногт зочиллоо.** CIS-нь манайд магадлан итгэмжлэл олгосон байгууллагуудын нэг. Хатагтай Alvarez сүүлийн 15 сарын туршид ОУДС дээр гарсан өөрчлөлттэй танилцахаар ирсэн юм. Түүнтэй уулзах цаг гаргасан эцэг эхчүүд болон багш нартаа талархал илэрхийлье.

2010 оны 9 сараас эхлэн ОУДС магадлан итгэмжлэлийн 5 жилийн үнэлгээгээ хийж эхэлнэ. Энэ үнэлгээг манайд магадлан итгэмжлэл олгосон байгууллагууд тодорхой шалгууруудын дагуу хийх юм. Үнэлгээний үр дүн 12-15 сарын дотор гардаг. Дэлхийн олон орны сургуулиуд сургалт, бусад үйл ажиллагаандаа тодорхой үнэлэлт өгөх үүднээс энэ үнэлгээг хийдэг юм. Энэ үнэлгээгээр дамжуулан тухайн сургууль үндэсний болон олон улсын магадлан итгэмжлэлийн шаардлагуудыг хэрхэн хангаж байгаагаа баталгаажуулдаг юм. Энэ үйл явцад сургуулийн нийт хамт олон болох багш нар, туслах ажилчид, үйлчлэгч, жижүүр, сургуулийн удирдлага, сурагчид, эцэг эхчүүд бүгд өөрсдийн хувь нэмрийг оруулдаг.

Цэцэрлэгийн том, бага ангийн сурагчид Лхагва гарагт гал сөнөөгч нартай уулзалт хийлээ. Тэд нар англи цагаан толгойн F үсэг үзэж байгаа юм. Улаанбаатар хотын Гал Командын багийхан дуудлагын машинтайгаа манай сургууль дээр айлчилсан юм. Сурагчид багш нарынхаа хамт гал сөнөөгч нар хэрхэн гал унтраахаар ус цацаж байгааг болон дуудлага авмагц машиндаа хэрхэн сууж байгааг ажигласан юм. Сурагчдад энэ уулзалт таалагдсан бөгөөд тэд гал сөнөөгч нартай хамт зургаа авахууллаа. Сургууль дээр байх хугацаандаа гал командын багийхан сургуулийн аюулгүй байдлыг бас мэргэжлийн нүдээр харж судаллаа. Манай сургууль дээр хүрэлцэн ирж сурагчидтай уулзалт хийсэн Улаанбаатар хотын Гал Командын багийханд болон тэднийг урьж сурагчидтай уулзалт хийлгэсэн Mrs. А. Туулд талархал илэрхийлье.

### **Номын Сан:**

Энэ жил манай сургуулийн номын санчаар Mrs. Michele Moller ажиллаж байгаа бөгөөд тэрээр Австралийн Сидней хотод болсон IB байгууллагын номын санчдын сургалтанд оролцоод ирлээ. Та бүхэн манай номын санд ирж хийгдсэн өөрчлөлтүүдийг хараарай. Хэрвээ та бүхэнд номын санд хандивлах номнууд байгаа бол бид хүлээж авах болно. Сурагчдын гарын авлага, уран зохиолын ном, хүүхдийн зохиол, сурагчдын төрөлх хэл дээр бичигдсэн номнууд бидэнд хэрэгтэй байгаа. Манай номын санд эцэг эхчүүдэд зориулсан жижиг булан бий. Эндээс эцэг эхчүүд та бүхэн өөрсдөө унших номоо бүртгүүлж авч унших боломжтой.

### **Олон Улсын Долоо Хоног:**

Олон Улсын Долоо Хоногийн өдрүүд амжилттай зохиогдож өнгөрлөө. Энэ 7 хоногийн турш үндэсний хувцсаа өмсөж зохион байгуулсан үйл ажиллагаанд амжилттай оролцсон нийт хамт олондоо баярлалаа. Бид бүгд энэ өдрүүдийг хөгжөөнтэй өнгөрүүллээ.

### **Аюулгүй байдлын талаар:**

Монголд гахайн ханиадаар өвчилсөн онош тодорлоо. ОУДС-ийн хамт олон бид бактерийн эсрэг савангаар сурагчдын гарыг угаалгаж мөн ханиаж найтаахдаа амаа таглаж, халуунтай бие нь муу байгаа сурагчдыг гэрт нь байлгах арга хэмжээг авч байна. Та бүхэн дараах вэб сайтуудаас ханиадны талаарх мэдээллийг авах боломжтой:

Center for Disease Control: <http://www.cdc.gov/h1n1flu/flyers.htm>  
[http://www.cdc.gov/flu/freeresources/2009-10/pdf/h1n1\\_take3.pdf](http://www.cdc.gov/flu/freeresources/2009-10/pdf/h1n1_take3.pdf)

Mongolia Ministry of Health: [www.moh.com](http://www.moh.com)

### **Машины Зогсоолын талаар:**

Та бүхэн сурагчдыг хичээлд нь хүргэж ирэхдээ тээврийн хэрэгслээ машины зогсоолд тавиарай. Хэрвээ жолооч нар тань хүүхдийг чинь хичээлд нь хүргэдэг бол хүүхдийг буулгахаасаа өмнө машинаа зогсоолд тавьж байхыг тэдэнд анхааруулж хэлээрэй. Манай сурагчдын аюулгүй байдал нь бидний хувьд хамгийн чухал асуудал байдаг юм.

### **Намрын Амралт:**

Намрын амралт маргааш эхэлнэ. 10 сарын 28-ны Лхагва гарагт сурагчдын хичээл орно. Та бүхэн сайхан амраарай.

**Захирал  
Greg Rayl**

### **ДУНД СУРГУУЛИЙН МЭДЭЭ**

Намрын амралт эхэлж цаг агаар өөрчлөгдөж байна. Хэд хэдэн өдөр хасах градустай байсан ч сурагчид өглөөдөө хичээлдээ богино ханцуйтай цамцтай ирсээр байна. Монгол орны цаг агаар нүд ирмэхийн зуур түргэн өөрчлөгддөг тул хүмүүс өвдөх нь амархан байдаг. Бид сурагчдыгаа битгий өвдөөсэй гэж хүсдэг. Түүнээс гадна та бүхэн гэртээ сурагчдын гарыг сайтар савандуулж угаалган ханиах буюу найтаахдаа амаа таглаж байхыг анхааруулна уу. Бидний гар бохирдсоноос болж бид амархан өвддөг.

Бид монгол хөөмий, уран нугаралтын үзүүлбэрээр Даваа гарагт олон улсын долоо хоногийн өдрүүдийг эхэлж олон үндэстний жагсаалаар Баасан гарагт энэ үйл ажиллагааг өндөрлөлөө. Хүүхдүүдээ дэмжиж тэдэнд үндэстний хувцсыг нь өмсгөж өөрсдийн улс үндэстнээр бахархах боломжийг олгосонд баярлалаа. ИВ хөтөлбөрт болон манай сургуулийн олон үндэстний соёлд аливаа үндэстэн бүр чухал үүрэгтэй байдаг.

Та нар хүүхдүүдээ хичээлд нь цагт нь ирүүлж байхыг би дахин сануулъя. Энэ жил бид анги дэвшүүлэх болон сурагчдын ирцийн талаарх журмыг хатуу мөрдөх болно. Энэ жил дунд сургуулийн сурагчдын ирцэнд Mr. Ricketts хяналт тавьж байгаа. Өвдөөгүй л бол сурагчид хичээлдээ тогтмол цагтаа ирж байх ёстой. Эцэг эхчүүд та нар болон сурагчид өөрсдөө “Эцэг Эх Сурагчдын Гарын Авлага” номыг уншиж танилцан гарын үсгээ зурсан. Энэ номонд бид сурагчдад тавьдаг шаардлагуудын талаар тодорхой бичсэн байгаа. Боловсролын байгууллагын хувьд бидэнд сурагчдад тавих шаардлагууд чухал байдаг.

Намрын амралт дуусмагц ACAMIS волейболын тэмцээн болно. Хятад явж сургуулиа олон улсын тэмцээнд төлөөлж оролцох багш сурагчиддаа баяр хүргэж амжилт хүсье.

Та бүхэн сайхан амраад 10 сарын 28-ны Лхагва гарагт хичээлдээ ирээрэй. Багш нар уламжлал ёсоор Даваа, Мягмар гарагт 2 өдөр мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдана. Бид бусад ИВ сургуулийн багш нарын нэгэн адил өөрсдийн мэргэжлийг дээшлүүлэх тал дээр анхаарч байх нь чухал. Энэ өдрүүдэд бид өөрсдийн сургах үйл явцад анхаарал хандуулж шилдэг багш нар болохын төлөө ажилладаг юм.

**Дунд Сургуулийн Эрхлэгч  
Betsy Hanselmann**

## **БАГА СУРГУУЛИЙН МЭДЭЭ**

### **Олон Улсын Долоо Хоног:**

Олон Улсын Долоо Хоногийг амжилттай зохион байгуулахад оролцсон бага сургуулийн нийт хамт олондоо талархал илэрхийлье. Энэ долоо хоногийн турш бага сургуулийн сурагчид зохиогдсон үйл ажиллагаанд амжилттай оролцлоо. Даваа гарагт болсон Монголын Өдөрлөгийн үеэр болон өнөө өглөө болсон өдөрлөгийн үеэр бид сайхан тоглолтууд үзлээ. Үндэсний хувцсаа өмссөн сурагчиддаа баярлалаа.

5-р ангийн сурагчид Мягмар гарагт багуудаа зохион байгуулж олон үндэстний тоглоомууд тоглолоо. Лхагва гарагт багууд асуулт хариултын тэмцээнд оролцлоо. Ногоон баг 2 онооны илүүтэйгээр бусдыгаа хошуучиллаа.

**Хичээл 10 сарын 28-ны Лхагва гарагт орно.** 10 сарын 26-ны Даваа, 27-ны Мягмар гарагуудад хичээл орохгүй.

**Бага Сургуулийн Эрхлэгч  
Jan Wiggins**

### **БИЕЙН ТАМИРЫН ТЭНХМЭЭС**

Волейболын баг тамирчид 10 сарын 29-нд Ningbo явахад бэлэн боллоо. Тамирчид бэлтгэлээ сайн хийж байна. Өнгөрсөн 7 хоногт хөвгүүдийн баг АДС-ийн багтай тоглож 3:0-р хожлоо. Охидын баг энэ долоо хоногт АДС-ийн багтай дахин тоглосон боловч хожигдсон. Гэхдээ тоглолтын оноо ойрхон байсан. Охид хөвгүүдийн багийн тэмцээн тамирчдын чадвар сайжирч байгааг харуулж байгаа бөгөөд бэлтгэл хийж эхэлснээс хойш тэдний тоглолтын ур чадвар сайжирсанд баяртай байна.

### **Сургууль дээр зохиогдсон арга хэмжээнүүд:**

1-р улиралд сурагчдын дунд олон төрлийн арга хэмжээнүүд зохиогдлоо. Монгол Үндэсний хувцасны өдөр, Албан ёсоор хувцаслах өдөр, Унтлагын хувцасны өдөр гэх мэт. Хөл бөмбөг болон волейболын тэмцээнүүд бас зохиогдсон. Багуудын авсан нийт оноог Англи эх хувиас харна уу.

**Биеийн Тамирын Тэнхмийн Эрхлэгч  
David Ricketts**